



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/319

Есөнбулаг сум

Нэршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/28 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийн загвар батлах тухай", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3/352 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Говь-Алтай аймгийн Гуулин багийн Ерөнхий боловсролын сургууль" гэснийг "Дэлгэр сумын Гуулин тосгоны ерөнхий боловсролын сургууль" болгон өөрчилсүгэй.

2. Сургуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан улсын бүртгэл, тамга тэмдэг, албан хэрэг хөтлөлт, мэдээллийн сан болон холбогдох баримт бичигт зохих өөрчлөлт оруулах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Дэлгэр сумын Гуулин тосгоны ерөнхий боловсролын сургуулийн захирал (Г.Чулуунцэцэг)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/27 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

